



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/313

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1 аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 25 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2022” нэгдсэн арга хэмжээнд оролцох үйл ажиллагааны зардалд 5,252,000 (Таван сая хоёр зуун тавин хоёр мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 5,252,000 (Таван сая хоёр зуун тавин хоёр мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П. Ариунбат)-т зөвшөөрсүгэй

3. Арга хэмжээнд нэгдсэн зохион байгуулалтай, оролцож, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН